



132

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 34

Есөнбулаг сум

Ёлтонгийн услалтын системийн
эзэмшлийг шийдвэрлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ийн “В” дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 20.1.14 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, 77.4 дахь хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ёлтонгийн услалтын системийг “Түлш Алтай” ХХК-д эзэмшүүлж, ашиглуулж байсан Өмч эзэмшлийн гэрээ дуусгавар болсон тул гэрээг цуцалсугай.

2. Аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д ДААЛГАХ НЬ:

2.1 Өмч эзэмшлийн гэрээ цуцлагдсантай холбогдуулан Ёлтонгийн услалтын системийн эзэмшилт, ашиглалтыг нь сайжруулан, бүрэн хүчин чадлаар нь ашиглах талаар шуурхай арга хэмжээ авч, “Ханлиг Тайшир Уул” ХХК-тай 2017 оны 04 дүгээр сард багтаан гэрээ байгуулан ажиллах;

2.2 Услалтын систем эзэмшигчтэй услалтын системийн сэргээн засварлалт, ашиглалт, хамгаалалт, үр ашгийг сайжруулах;

2.3 Услалтын системийн өмч эд хөрөнгөд дахин үнэлгээ хийлгэн, шинэ эзэмшигчид хүлээлгэн өгөх;

2.4 Цаашид уг услалтын системийг илүү үр өгөөжтэй, бүрэн хүчин чадлаар нь ашиглуулах тал дээр бодлого барьж ажиллах;

3. “Ханлиг Тайшир Уул” ХХК-нд ДААЛГАХ НЬ:

3.1. Ёлтонгийн услалтын системийн толгойн барилга, шугам хоолойн техник тоног төхөөрөмжийн засвар үйлчигээг өөрийн хөрөнгөөр цаг тухай бүрд нь хийж ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах;

3.2 Монгол Улсын Засгийн газар болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан орон нутгийн иргэдийг төмс, хүнсний ногоогоор хангах зорилтыг хэрэгжүүлэхэд нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах;

0000131

4. Уг тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2009 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 43 дугаар тогтоолын хавсралт жагсаалтын 3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

~~ДАРГА  Т.ГАНЗОРИГ~~